

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 11 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаараа Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хуулийн төслийн хэрэгжиж эхлэх хугацаа, хуулийн төсөл батлагдсанаар хэдэн эмэгтэй цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлөх, төсөвт үүсэх ачааллын талаар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэллэгийг хууль зүйн техникт нийцүүлэн жигдлэх, хуулийн дагаж мөрдөх хугацааг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс байхаар зарчмын зөрүүтэй 3 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.


Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,


Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



П.АНУЖИН



**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "Эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон" гэсний дараа "амаржсаны," гэж нэмж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 17¹ дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"5.Цэргийн алба хаагч эмэгтэйн энэ хуулийн 17¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацааны төлбөл зохих эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон сар бүр улсын төсвөөс хариуцан төлөх ба шимтгэлийг тухайн алба хаагчийн анги, байгууллага нийгмийн даатгалын байгууллагад тайлагнаж, шилжүүлнэ."

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг

3.Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө."

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг